

“Фронтнер Лэнд Групп” ХК-ийн Хувьцаа Эзэмшигчдийн хурлын тэмдэглэл

2023.04.28

Улаанбаатар хот

“Фронтнер Лэнд Групп” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 04 сарын 28-ны өдөр 11:00 цагт Пума Имperiал зочид буудлын хурлын бага танхимд эхлэв.

Хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийг холбогдох журмын дагуу бүртгэв.

Тооллогын комиссын дарга С. Бат-Эрдэнэ

Саналын эрхтэй нийт хувьцааны 80,58%-ийг эзэмшиж буй 5 хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байгаа нь хурлыг хүчинтэйд тооцох үндэслэл болсон тул хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцон тооллогын комиссын дарга тогтоолыг уншиж танилцуулав.

Хурлын дарга Д. Машбат:

Хурлын дарга Д. Машбат хурлыг нээж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлуудыг танилцуулав. Үүнд:

- Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
- Компанийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлах
- Компаний дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн батлах
- ТУЗ-н гишүүд сонгож, томилох
- Ногдол ашиг хувиарлах эсэх тухай тайлагнах
- Бусад

Ирсэн байгаа таван хувьцаа эзэмшигчдээс нэмэлтээр асуух асуулт байгаа юу?

Хувьцаа эзэмшигчид: Нэмэлт асуудлаар “Морьт Импекс” ХХК-тай холбоотой гэрээг шинэчлэн, сунгах асуудлыг хэлэлцэх хүсэлтэй байна. Учир нь энэ компаниас авах авлагатай тул гэрээг үргэлжлүүлэн сунгах шаардлагатай байна.

Хувьцаа эзэмшигч А. Дагзмаа: Одоогоор өөр нэмэлт хэлэлцүүлэх санал алга.

Хурлын дарга Д. Машбат: Эхний асуудлаасаа эхлээд хэлэлцэж эхэлье. Бизнес төлөвлөгөө болон 2022 оны үйл ажиллагааны тайлантай танилцъя. Үйл ажиллагааны хувьд өнгөрсөн 2022 онд өмнөх хувьцаа эзэмшигчдийн хурлаар танилцуулсан бизнес төлөвлөгөөний дагуу ажилласан гэж ойлгож байна. 2023 оны бизнес төлөвлөгөө эхлээд 4 сар явж байгаа гэж хувьцаа эзэмшигчид ойлгож байгаа. Мөн 2022 онд “Фронтнер Лэнд Групп” ХК нь ашигтай ажиллахаар идэвхитэй үйл ажиллагаа явуулаагүй. Санхүүгийн тайлангаас та бүхэн харж байгаа байх, зөвхөн цалингийн зардлууд, урсгал зардлууд

гарснаас бусдаар өөр зардал гараагүй харагдаж байна. Санхүүгийн тайланд “Сүлд аудит” ХХК аудит хийн баталгаажуулсан байна. Хөрөнгө оруулалтын хувьд нэмэгдсэн зүйл байхгүй байна. Хувьцаа эзэмшигчид маань 2022 оны санхүүгийн тайлантайгаа танилцсан уу?

Хувьцаа эзэмшигч А. Дагзмаа: Танилцаж байна. Хараахан харж амжаагүй байлаа. Ер нь урсгал зардлаас өөр гарсан, оновчтой зүйл байхгүй юм байна. Өмнөх онуудын тайлантайгаа төстэй харагдаж байна.

Хурлын дарга Д. Машбат: Тийм, Идэвхитэй үйл ажиллагаа явуулаагүй, Одоогоор хөрөнгө оруулалт татах, үйл ажиллагаагаа тогтвортой явуулах чиглэлд анхааран, ажиллаж байгаа. Чекээр авсан их хэмжээний зарлага харагдаж байна. Үүнийг компанид хөрөнгө оруулалт татахад чиглэсэн үйл ажиллагаанд зарцуулсан гэж ойлгож байна.

Хувьцаа эзэмшигч А. Дагзмаа: Одоо ирээдүйн үйл ажиллагааны талаар хэлэлцмээр байна.

Хурлын дарга Д. Машбат: Тэгэхлээр эхний асуудлын хувьд хувьцаа эзэмшигчдийг танилцсан, зөвшөөрсөн гэж ойлгож болох уу?

Хувьцаа эзэмшигчид: Тийм.

Хурлын дарга Д. Машбат: Хоёрдугаар асуудалд компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө буюу бизнес төлөвлөгөөг батлах тухай байна. Бизнес төлөвлөгөөг өнөөдрийн гол гурван хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл өөрсдөө гардаж боловсруулсан. /Бизнес төлөвлөгөөг танилцуулав./

Хурлын дарга Д. Машбат: Хувьцаа эзэмшигчдийн зүгээс бизнес төлөвлөгөөн дээр өөр асуух асуулт байгаа юу?

Хувьцаа эзэмшигчид: Байхгүй.

Хурлын дарга Д. Машбат: Бизнес төлөвлөгөөн дээр өөр нэмэлт асуулт байхгүй бол 2023 оны бизнес төлөвлөгөөг зөвшөөрсөн гэж үзэж байна.

Хувьцаа эзэмшигчид: Тийм ээ, танилцлаа.

Хурлын дарга Д. Машбат: Дараагийн хэлэлцэх асуудал Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай байна. Энэ дээр нэмэлт өөрчлөлт оруулах санал ирээгүй байна.

Хувьцаа эзэмшигчид: Тэгвэл саналын хуудсан дээрээ татгалзах гэдгээр бөглөх үү?

Хурлын дарга Д. Машбат: Тийм ээ, Болно.

Хурлын дарга Д. Машбат: Дөрөвдүгээр хэлэлцэх асуудалд Компанийн ТУЗ-ийг сонгох, батлах тухай байна. Сүүлд ТУЗ-аас гурван хүн гарах хүсэлтээ өгөөд гарсан. Тийм учраас

шинэ гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурал хүртэл түр томилох шаардлагатай болсон. Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар дахин томилж, батлах тухай хэлэлцэнэ. Та бүхэн ТУЗ-ийн гишүүдийн танилцуулгыг дэлгэцэн дээрээс харна уу. Зарим нэр дэвшигчид ирсэн байна. Асуух зүйл байвал асуугаарай.

Хувьцаа эзэмшигч А. Дагзмаа: Өөрчлөгдсөн юм байхгүй юм байна.

Хурлын дарга Д. Машбат: Тийм. Саналын хуудсан дээрээ та саналаа бичээд өгөхөд болно.

Хурлын дарга Д. Машбат: За үндсэн сүүлийн хэлэлцэх асуудал бол ногдол ашиг хувиарлахгүй талаар байгаа. Энэ жил ашигтай ажиллаагүй учраас ногдол ашиг хувиарлахааргүй гэж ТУЗ шийдсэн.

Хувьцаа эзэмшигч А. Дагзмаа: Өмнө жилийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар уг нь хувиарлана гэж ярьж байсан. Одоо яахав дээ боломжгүй болсон бол. Санхүүгийн тайлан дээрээ ашиггүй гарсан байна.

Хурлын дарга Д. Машбат: За бусад буюу нэмэлт хэлэлцэх асуудлаар гол хувьцаа эзэмшигч, үүсгэн байгуулагч байсан “Морьт Импекс” ХХК-тай хийсэн гэрээний талаар оруулах хүсэлтэй байна.

Хувьцаа эзэмшигч Камолиддин Талипов: “Морьт Импекс” ХХК-иас миний санахаар 4.5 тэрбум төгрөгийн авлагатай. Тийм учраас гэрээний хугацаа дуусвал асуудал үүсэх байх. Энэ нь өөрөө их хэмжээний хэлцэл, гэрээг одоо ахин сунгахдаа шинэчлэн хийх гэдэг заалтыг оруулан үүрэг өгөх хэрэгтэй байна. Хөөн хэлэлцэх хугацаа дуусахаас өмнө гэрээг шинэчлэн хийж, сунгаж авлагаа авах ёстой гэж бодож байна.

Хувьцаа эзэмшигч А. Дагзмаа: Тэр их мөнгийг зүгээр ингээд хаячиж болохгүй байх аа.

Хувьцаа эзэмшигч Камолиддин Талипов: “Морьт Импекс” ХХК-иас жил бүр байнга нэхдэг, Өгнөө одоо зээл бүтэж байна, концесс бүтэж байна гэсэн хариу байнга өгч байгаа.

Хурлын дарга Д. Машбат: За дараагийн асуудал бол ТУЗ-ийн цалин урамшууллын төсөв батлах тухай байна. Энэ дээр хувьцаа эзэмшигчдийн зүгээс санал байна уу?

Хувьцаа эзэмшигчид: Ашиггүй ажиллаж байгаа юм чинь нэмэгдэх зүйлгүй гэж бодож байна. Хуучин хэвээр нь байлгах саналтай байна.

Хурлын дарга Д. Машбат: Өнөөдрийн хурлын үндсэн асуудлуудаа дууссанд тооцох уу?

Хувьцаа эзэмшигч А. Дагзмаа: Тийм байна.

Хурлын дарга Д. Машбат: За 2023 оны 04-р сарын 28-ны өдрийн “Фронтинер Лэнд Групп” Үндсэн 5 асуудал мөн бусдаар хэлэлцэх асуудал шийдвэрлэгдлээ гэж үзэж байна.

Тооллогын комиссын дарга С. Бат-Эрдэнэ: “Фронттиер Лэнд Групп” ХК-ийн өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн нийт 7-н асуудлын 6-г тус тус зөвшөөрсөн 7,455,577 ширхэг хувьцаа буюу 100%-ийн саналаар дэмжигдлээ. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах ямар нэгэн санал ирээгүй тул тус асуудлыг 7,455,577 ширхэг хувьцаа буюу 100%-ийн саналаар татгалзсан байна. Шинээр сонгогдсон ТУЗ-ийн гишүүдэд амжилт хүсье. Компанийг үр ашигтай ажиллахад хувь нэмэр оруулж, хуулийн дагуу ажиллахыг хүсье.

Хурлын дарга Д. Машбат: Хурлын дарга хурлаас гарсан шийдвэр тогтоолыг уншиж танилцуулав.

Хурлын дарга Д. Машбат хурлыг хаав.

Хурал: 12:35 минутанд өндөрлөв.

Тэмдэглэл хөтөдсөнА.Амирлан

Хянасан:

Хурлын даргаД. Машбат

